

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах,
2. Нийгмийн даатгалын тухай хууль, Засгийн газрын 251 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах,
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 30-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Чинбат, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхамсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

В. М
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Д.Б
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:
ХҮЛЭГТХҮННУ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

И.Г
И.ГҮРРАГЧАА

ЗӨВШӨӨРСӨН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЧИНБАТ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ЛХАМСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харуулагч албан тушаалтанд харууллага тооцүүлэхгаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/167

Улаанбаатар хот

САГ- 2020/65/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Турбогенератор №7-ын их засварын ажлын Үнэлгээний хорооны баталсан тендер шалгаруулалтын шалгуур үзүүлэлтэнд Эрчим хүчний яамны 3.4.4 заалтын дагуу ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай гэж тусгасан боловч тендерт шалгарсан компани 3.4.3 заалтын дагуу тусгай зөвшөөрөлтэй байсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12.3-т "... захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ", эсвэл 28.7.1-д "... захиалагч энэ хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно", 28.14.6-д "санхүүгийн саналыг энэ хуулийн 28.2-28.7-г баримтлан үнэлж, гэрээ байгуулах эрхийг «хамгийн сайн» гэж үнэлэгдсэн тендерт оролцогчид олгох" гэж заасанд тус тус нийцээгүй байна.

- Нийгмийн даатгалын тайланд ээлжийн амралтын олговрыг тухайн сард ногдох орлогоор нь харгалзах сард хуваарилдаггүй, мөн хөдөлмөрийн хөлс болон ээлжийн амралтын олговрыг 2 салгаж тайлагнаснаас даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг илүү, дутуу суутгасан бөгөөд илүү, дутуу суутгуулсан ажилтнуудыг тэтгэвэрт гарах бүрт нийгмийн даатгалын залруулгын тайлан бэлтгэдэг нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.7-д "Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно", 17.1-д "Ажил олгогч нь доор дурдсан үүрэг хүлээнэ: 1/ хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх, ...3/ нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах", Засгийн газрын 251 дүгээр тогтоолын 2-т "Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосугай" гэж заасанд тус тус нийцээгүй.

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, талбарийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чалгах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харилцаж албан тушаалтанд харилцаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Alban_Shaardлага\2020\03\25\САГ_Док

001080578



5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо	2020.03.13	Аудитын нэр	"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код	САГ-2020/65/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр			"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК	сая төгрөгөөр	

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаа	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	Балансын данстай холбоотой асуудал	1	Бүртгэлийн програм нь капиталжсан хөрөнгийн элэгдлийг тооцохдоо цаашид ашиглах хугацаанд элэгдүүлдэггүй, хөрөнгийн нийт ашиглах хугацаанд элэгдүүлсэн байна	-	Зөвлөмж өгсөн	2020.03.13	1	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч	Ч.Чинбат, Ц.Лхамсүрэн Ж.Ганццэг, Н.Цэрэнжав
2	Зардлын данстай холбоотой асуудал	1	Нийгмийн даатгалын тайланд эзлэгийн амралтын олговрыг тухайн сард ногдох орлогоор нь харгалзах сард хуваарилдаггүй, мөн хөдөлмөрийн хөлс болон эзлэгийн амралтын олговрыг 2 салгаж тайлагнаснаас даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг илүү, дутуу суутгасан бөгөөд илүү, дутуу суутгуулсан ажиглалтуудыг тэтгэвэрт гарах бүрт нийгмийн даатгалын зарцуулгын тайлан бэлтгэдэг	1.20	Албан шаардлага өгөх	2020.03.13	3	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч Цалингийн нягтлан бодогч	Ч.Чинбат, Ц.Лхамсүрэн Ж.Ганццэг, Ц.Хажидмаа
3	Балансын данстай холбоотой асуудал	1	Дансанд олон жил хуримтлагдсан бараа материалын үнэ цэнийн тооцож үзэхэд нийт бараа материалын 19.6 хувийг эзэлж буй, тавьас дээш жилийн насжилттай, ашиглах боломжтой, үнэ цэнийн бууралтыг тооцох шаардлагатай бараа материал санхүүгийн тайланд толилуулагдсан	-	Зөвлөмж өгсөн	2020.03.13	2	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч Материалын нягтлан бодогч	Ч.Чинбат, Ц.Лхамсүрэн Ж.Ганццэг, Б.Сайнзаяа
4	Балансын данстай холбоотой асуудал	1	Турбогенератор №7-ын их засварын ажлын Үнэлгээний хорооны баталсан тендер шалгаруулалтын шалгуур үзүүлэлтэд Эрчим хүчний яамнаас олгосон 3.2.1, 3.4.4, 3.5.4, 3.8.2 тоот тусгай зөвшөөрлүүдтэй байх шаардлагатай гэсэн боловч тендерт шалгарсан компани 3.4.4 тоот тусгай зөвшөөрөлгүй байсан.	-	Албан шаардлага өгөх	2020.03.13	4	Гүйцэтгэх захирал Үнэлгээний хорооны дарга Засвар хяналтын албаны дарга	Ч.Чинбат, Л.Нямхүү Ц.Батмагнай
Дүн				1.20					

4.5 Аудит хийсэн зорилтот түвшний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	Зөрүү төлөвлөснөөс	
1	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч	мян.квтц	1,040,104.0	1,054,299.3	14,195.3	
	ДХЦЭХ	хувь	16.60	16.44	(0.16)	
		мян.квтц	172,635.0	173,327.2	692.2	
	Эрчим хүчний түгээлт	ЦЭХ	мян.квтц	867,469.0	880,972.0	13,503.0
		ДЭХ	Гкал	2,221,717.0	2,214,207.0	(7,510.0)
	Үнийн дүнгээр	ЦЭХ	төг	90,612,805,670.0	91,363,274,724.0	750,469,054.0
ДЭХ		төг	24,696,698,775.0	24,517,713,831.0	(178,984,944.0)	
2	Нийт орлого	төг	116,239,338,045.0	116,904,466,889.6	665,128,844.6	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төг	115,309,504,445.0	115,880,988,556.2	571,484,111.2	
	Үйл ажиллагааны бус орлого	төг	929,833,600.0	1,023,478,333.4	93,644,733.4	
3	Нийт зардал	төг	116,239,338,068.0	119,589,379,988.2	3,350,041,944.2	
	Үүнээс: Удирдлагын зардал	төг	315,436,144.6	303,653,541.2	(11,782,603.4)	
	Үйл ажиллагааны бус зардал	төг	633,673,840.0	834,417,928.1	200,744,088.1	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал -/	төг	-	(2,684,913,098.6)	(2,684,913,098.6)	
5	Цэвэр ашиг / алдагдал -/	төг	-	(2,772,961,088.5)	(2,772,961,088.5)	
6	Төрийн өмчийн ногдол ашиг	төг	-	-	-	
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	(0.0)	
8	Нийт авлага	төг	7,740,000,000.0	8,562,527,464.8	822,527,464.8	
	Үүнээс: Найдваргүй	төг	-	-	-	
9	Нийт өглөг	төг	31,993,400,000.0	34,060,346,635.8	2,066,946,635.8	
	Богино хугацаат өр төлбөр	төг	10,213,500,000.0	12,209,432,295.9	1,995,932,295.9	
	Урт хугацаат өр төлбөр	төг	21,779,900,000.0	21,850,914,339.9	71,014,339.9	
10	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	төг	22,375,300,000.0	14,452,015,757.9	(7,923,284,242.1)	
11	Нийт ажиллагсдын тоо	тоо	996.0	994.0	(2.0)	
12	Нийт цалингийн сан	төг	27,623,684,000.0	26,802,536,300.0	(821,147,700.0)	
13	Нэг ажиллагчийн дундаж цалин /жүд/	төг	2,311,218,540.8	2,247,026,852.8	(64,191,688.0)	

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	99,362,782,973.56	100,760,943,463.55	-	(22,680,901,419.22)	177,442,825,017.89
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,081,487,688.24)	(1,081,487,688.24)
Өмчид гарсан өөрчлөлт	38,694,650,000.00	-	-	-	38,694,650,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	9,067,676,794.74	-	279,787,406.26	9,347,464,201.00
2018 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	138,057,432,973.56	109,828,620,258.29	-	(23,482,601,701.20)	224,403,451,530.65
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(2,772,961,088.46)	(2,772,961,088.46)
Өмчид гарсан өөрчлөлт	(38,694,650,000.00)	-	38,694,650,000.00	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(385,850,947.32)	-	385,850,947.32	-
2019 оын 12 сарын 31-р үлдэгдэл	99,362,782,973.56	109,442,769,310.97	38,694,650,000.00	(25,869,711,842.34)	221,630,490,442.19

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	106,305,272,522.88	115,538,050,616.04
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	105,014,938,618.24	114,683,081,587.84
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	223,546,892.00	231,267,484.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,066,787,012.64	623,701,544.20
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	97,102,872,670.02	101,582,948,097.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	19,924,865,045.02	25,061,507,838.14
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,981,000,000.00	7,475,500,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	50,380,775,700.10	47,958,393,732.80
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,837,015,276.89	1,677,413,643.28
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,595,666,542.16	8,333,802,196.02
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	63,472,729.18	68,229,598.86
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	7,012,917,715.63	9,060,898,116.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	112,512,622.20	84,726,026.05
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,194,647,038.84	1,862,476,945.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,202,399,852.86	13,955,102,518.81
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	425,810,812.99	170,282,540.44
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	425,810,812.99	170,282,540.44
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,767,422,998.06	14,620,848,245.59
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,738,840,498.06	14,527,483,245.59
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,582,500.00	93,365,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,341,612,185.07)	(14,450,565,705.15)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	201,830,947.21	213,415,199.33
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	201,830,947.21	213,415,199.33
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(201,830,947.21)	(213,415,199.33)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,341,043,279.42)	(708,878,385.67)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,202,558,660.64	1,861,515,381.22
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,861,515,381.22	1,152,636,995.55



4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	112,093,663,730.65	115,880,988,556.19
02	Борлуулалтын өртөг	103,818,953,637.00	108,898,851,833.54
03	Нийт ашиг(алдагдал)	8,274,710,093.65	6,982,136,722.65
04	Түрээсийн орлого	57,056,024.21	82,750,459.89
05	Хүүний орлого	425,810,812.99	170,282,540.44
08	Бусад орлого	1,436,280,268.34	736,116,467.47
09	Борлуулалт, маркетингийн зардал	247,336,004.60	251,549,266.97
10	Ерөнхий ба удирдлагын зардал	6,925,447,884.52	7,333,365,505.82
11	Санхүүгийн зардал	427,051,186.58	392,050,888.35
12	Бусад зардал	3,687,470,588.43	2,711,551,431.29
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	17,500,235.48	6,933,076.16
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	37,041,622.52	25,384,727.28
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,038,906,606.94)	(2,684,913,098.54)
19	Орлогын татварын зардал	42,581,081.30	88,047,989.92
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,081,487,688.24)	(2,772,961,088.46)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,081,487,688.24)	(2,772,961,088.46)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз, (гарз)		
24	Орлогын нийт дүн	(1,081,487,688.24)	(2,772,961,088.46)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,861,515,381.22	1,152,636,995.55
1.1.2	Дансны авлага	8,269,057,413.46	8,409,965,669.17
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	18,723,902.88	53,338,784.32
1.1.4	Бусад авлага	85,293,414.29	99,223,011.29
1.1.6	Бараа материал	10,263,530,840.62	11,872,190,590.17
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	353,621,543.70	4,905,738,613.34
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,851,742,496.17	26,493,093,663.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	196,317,730,986.38	189,783,675,454.25
1.2.2	Биет бус хөрөнгө	39,119,302,865.49	39,076,051,668.24
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	204,765,158.10	204,765,158.10
1.2.9	Дуусаагүй барилга	78,834,409.45	133,251,133.57
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	235,720,633,419.42	229,197,743,414.16
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	256,572,375,915.59	255,690,837,078.00
2	Өр төлбөр ба эзэмшигчийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,029,887,605.26	9,939,769,863.85
2.1.1.2	Цалингийн өглөг	2,908,371,054.00	(0.00)
2.1.1.3	Татварын өр	279,297,423.23	139,340,829.75
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,938,135,162.16	1,934,875,035.29
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,149,649.12	4,819,329.76
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	76,053,516.78	190,627,237.22
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,234,894,410.55	12,209,432,295.87
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	19,958,283,667.98	17,045,288,055.86
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,616,657,358.28	1,687,677,094.20
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,359,088,948.13	3,117,949,189.88
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	23,934,029,974.39	21,850,914,339.94
2.2	Өр төлбөрийн нийт дүн	32,168,924,384.94	34,060,346,635.81
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: -Төрийн өмч	138,057,432,973.56	99,362,782,973.56
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	109,828,620,258.29	109,442,769,310.97
2.3.8	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	38,694,650,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг алдагдал	(23,482,601,701.20)	(25,869,711,842.34)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	224,403,451,530.65	221,630,490,442.19
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	256,572,375,915.59	255,690,837,078.00

2. Бүртгэлийн програм хангамжтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бүртгэлийн програм нь капиталжсан хөрөнгийн элэгдлийг тооцохдоо цаашид ашиглах хугацаанд элэгдүүлдэггүй, хөрөнгийн нийт ашиглах хугацаанд элэгдүүлсэн байна.

2.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн элэгдэл буруу дүнгээр илэрхийлэгдсэн байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Бүртгэлийн програмд хөгжүүлэлт, сайжруулалт хийлгэн, дахин тооцооллын алдаа гаргахгүй байх талаар хяналт тавин ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын үнэ цэнтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Дансанд олон жил хуримтлагдсан бараа материалын үнэ цэнийг тооцож үзэхэд нийт бараа материалын 19.6 хувийг эзэлж буй, таваас дээш жилийн насжилттай, ашиглах боломжтой, үнэ цэний бууралтыг тооцох шаардлагатай бараа материал санхүүгийн тайланд толилуулагдсан байна. Энэ нь НББОУС 2(9) "Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжинэ", НББОУС 2(28) "Бараа материал нь бүхэлдээ буюу хэсэгчлэн хоцрогдолд орсон, эсвэл тэдгээрийн борлуулалтын үнэ цэнэ буурсан бол бараа материалын өртөг нь нөхөгдөхгүй болж болох юм. Мөн бараа материалыг иж бүрдэл болгох тооцоолсон зардал өссөнөөр бараа материалын өртөг нөхөгдөхгүй байж болно. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулах хөрөнгийг түүний борлуулалт эсвэл ашиглалтаас хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй дүнгээс өндөр дүнгээр тусгаж болохгүй..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар нь хэмжиж тайлагнаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Технологийн хоцрогдолд орсон бараа материалын үнэ цэний бууралтыг тооцох, үнэлүүлэх талаар холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

хүүг төгрөгөөр тооцож тогтоосон хугацаанд зээлдүүлэгчид төлнө” гэсэн заалтын дагуу гэрээний төлбөрийн хуваарийг бэлтгээгүйгээс 76.6 сая төгрөгийн хүүгийн зөрүү үүссэн. Аудитын явцад үйлчлүүлэгчид холбогдох байгууллагаас тодруулах талаар хүсэлт гаргасан боловч шалгалтын хугацаанд хариу ирүүлээгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“ДЦС-3” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, концессын мэдээлэл, их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, мэдээллүүдийг хуульд заасан хугацаанд оруулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 9.6 сая төгрөгийг барагдуулсан, 3,475.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлснээс 5 албан шаардлагыг 100 хувь, 1 албан шаардлагыг 30 хувийн үнэлгээтэй хэрэгжүүлсэн байна.

Нийт 1,129.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн буюу зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

харуулах зүйлсийг зохистой бөгөөд үнэн зөв илэрхийлэх ёстой..." гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

7. Үндсэн хөрөнгийн элэгдлээс үүсэх хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь Сангийн сайдын 121 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"-ын 5.1-д "Татвар ногдох түр зөрүүнээс үүсэж буй татварын нөлөөллийг "Хойшлогдсон татварын өглөг" дансаар зохицуулан бүртгэнэ", 5.2-т "Хасагдах түр зөрүүнээс үүсэж буй татварын нөлөөллийг "Хойшлогдсон татварын хөрөнгө" дансаар зохицуулан бүртгэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

8. Нийгмийн даатгалын тайланд ээлжийн амралтын олговрыг тухайн сард ногдох орлогоор нь харгалзах сард хуваарилдаггүй, мөн хөдөлмөрийн хөлс болон ээлжийн амралтын олговрыг 2 салгаж тайлагнаснаас даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тайлант онд 1.6 сая төгрөгөөр илүү, 0.4 сая төгрөгөөр дутуу суутгасан бөгөөд өмнөх онд илүү, дутуу суутгуулсан ажилтнуудыг тэтгэвэрт гарах бүрт нийгмийн даатгалын залруулгын тайлан бэлтгэдэг нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.7-д "Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно", 17.1-д "Ажил олгогч нь доор дурдсан үүрэг хүлээнэ: 1/ хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх, ...3/ нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах", Засгийн газрын 251 дүгээр тогтоолын 2-т "Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосугай" гэж заасанд тус тус нийцээгүй бөгөөд ирээдүйд ихээхэн үр нөлөө үзүүлэхээр байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх


Аудитаар илэрсэн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараах 2 асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Үнсэн сан шинээр бариулах ажлын тендерийн материал болон гэрээний хэрэгжилтийг шалгахад горим төлөвлөсөн боловч Авилгатай тэмцэх газраас уг тендерийн материалыг шалгаж байгаа гэсэн тайлбарыг удирдлагаас өгсөн. Авилгатай тэмцэх газар руу тус материалыг шалгаж байгаа болон гаргаж өгөх боломжтой эсэх талаар хариу авахаар албан бичгээр хандсан боловч аудитын шалгалтын хугацаанд хариу ирээгүйгээс аудитаар төлөвлөсөн горимоо хэрэгжүүлж чадаагүй.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан 6 зээлийн хүүгийн тооцооллыг шалгаснаас 5 зээл нь Засгийн газрын 284 дүгээр тогтоолын дагуу хойшлогдсон хүүгийн үлдэгдэлтэй байсан. Тус 5 зээлийн хүүгийн тооцоолол, үлдэгдлийн дүнг давтан тооцоолоход 1 зээлийн хүү холбогдох гэрээ, гэрээний хавсралтын дагуу бэлтгэгдэн санхүүгийн тайланд тусгагдсан бөгөөд үлдсэн 4 зээлийн хойшлогдсон хүүгийн тооцоолол, үлдэгдлийн хувьд зээлийн гэрээ тус бүрийн "Зээлдэгч нь ашигласан зээлийн өрийн үлдэгдэлд жилийн 1.75/2 хувьтай тэнцэх



үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно", "Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

2. Шүүхийн шийдвэрээр шийдвэрлэгдсэн 4.0 сая төгрөгийн алдангийн авлага, орлогыг бүртгээгүй орхигдуулсан бөгөөд 0.3 сая төгрөгийг уурын борлуулалтын авлагаар буруу ангилан бүртгэсэн нь СТОУС-ын СҮБ(4.47)-д "Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн өсөлтийг найдвартай хэмжих боломжтой ба энэ нь хөрөнгийг нэмэгдүүлж, эсвэл өр төлбөрийг багасгаж байвал орлогын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

3. Турбогенератор №7-ын их засварын ажлын Үнэлгээний хорооны баталсан тендер шалгаруулалтын шалгуур үзүүлэлтэнд Эрчим хүчний яамны 3.4.4 заалтын дагуу ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай гэж тусгасан боловч тендерт шалгарсан компани 3.4.3 заалтын дагуу тусгай зөвшөөрөлтэй байсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12.3-т "... захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ", эсвэл 28.7.1-д "... захиалагч энэ хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно", 28.14.6-д "санхүүгийн саналыг энэ хуулийн 28.2-28.7-г баримтлан үнэлж, гэрээ байгуулах эрхийг «хамгийн сайн» гэж үнэлэгдсэн тендерт оролцогчид олгох" гэж заасанд тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Барилга байгууламжийн дахин үнэлгээний тайланд цаашид ашиглах жилийг нийт ашиглалтын хугацаагаар тооцохоор тусгасан боловч тус ашиглалтын хугацааны өөрчлөлтийг бүртгэлийн програмд оруулаагүйгээс тайлант жилийн барилга байгууламжийн элэгдлийн зардлыг 2,720.8 сая төгрөгөөр дутуу тооцсон нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

5. Урт хугацаат 1,026.9 сая төгрөгийн, богино хугацаат 155.4 сая төгрөгийн зээлийн хүүг урт болон богино хугацаат зээлийн үзүүлэлтээр ангилан толилуулсан нь Сангийн сайдын 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-т "Богино хугацаат зээлийн хэсэгт нэг хүртэлх жилийн хугацаатай авсан зээл хамаарна", "Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг урт хугацаат зээл хэсэгт толилуулна", "Богино болон урт хугацаат зээл, өрийн үнэт цаастай холбоотой үүссэн, төлөгдөөгүй байгаа хүүгийн төлбөрийн дүнг энд тусгана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

6. Засварын зардлын 1.6 сая төгрөгийн залруулгыг борлуулалтын орлогоор бүртгэсэн нь СТОУС-ын СҮБ (ЧШ4)-д "Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд үүгээр

116,904.5 сая төгрөгийг орлого олж төлөвлөгөөг 0.6 хувиар буюу 665.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Цахилгаан эрчим хүч түгээх орлого	90,612.8	91,363.3	750.5	0.8
Дулаан эрчим хүч түгээх орлого	24,696.7	24,517.7	(179.0)	(0.7)
Үйл ажиллагааны бус орлого	929.8	1,023.5	93.6	10.1
Нийт орлого	116,239.3	116,904.5	665.1	0.6

Тайлант онд диспетчерийн зохицуулсан цахилгаан болон дулаан түгээлтийн төлөвлөгөөг цахилгаан эрчим хүчинд 100.6 хувь, дулааны эрчим хүчинд 100 хувь биелүүлж ажилласан нь Эрчим хүчний сайдын тушаалаар батлуулсан төлөвлөгөөний биелэлтэд цахилгааны эрчим хүч түгээх орлогыг 0.8 хувиар буюу 750.5 сая төгрөгөөр давуулан, дулаан эрчим хүч түгээх орлогыг 0.7 хувиар буюу 179.0 сая төгрөгөөр бууруулах гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК нь 116,239.3 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөн батлуулснаас, 55,270.9 сая төгрөгийг түлшний зардалд, 31,152.8 сая төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал болон нийгмийн даатгалын зардалд, 18,292.9 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд, 2,642.7 ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардалд, 2,642.7 сая төгрөгийг ажилчдын нийгмийн зардалд, 1,606.5 сая төгрөгийг ашиглалтын зардалд, 1,567.7 сая төгрөгийг урсгал засварын зардалд, 1,475.2 сая төгрөгийг төсөвт төлөх татвар, хураамж, төлбөрт, 637.3 сая төгрөгийг удирдлагын зардалд, 3,593.4 сая төгрөгийг бусад зардалд тус тус гаргахаар төлөвлөжээ.

Батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлын нийт гүйцэтгэл 119,589.3 сая төгрөг гарч тайлант жилд 3,350.0 сая төгрөгийн зардлын хэтрэлттэй ажиллажээ. Үүнд дахин үнэлгээний дараах барилга байгууламжийн элэгдлийн зардлыг 2,720.8 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн, мөн түлшний үнэ өссөнтэй холбоотойгоор 1,187.4 сая төгрөг хэтэрсэн нь голлох нөлөө үзүүлсэн.

Хөрөнгө оруулалт, их засварын ажилд 22,375.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 14,452.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд нийт зөрүүнээс 6,089.4 сая төгрөгийн 10 ажлын хугацаа хойшлогдож, үлдсэн 1,833.8 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.

Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдалгүй байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,684.9 сая төгрөгийн алдагдалтай гарсан байна. Энэ нь дахин үнэлгээний дараах барилга байгууламжийн элэгдлийн зардлыг 2,720.8 сая төгрөгөөр дутуу тооцон төлөвлөсөнтэй холбоотой байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл тодорхойлж, нийт 32 горим, сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 4,010.6 сая төгрөгийн 10 асуудалд алдаа, зөрчил илэрснээс, 4,009.4 сая төгрөгийн 6 асуудлын алдааг залруулж, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Санхүүгийн тайланд 1.0 сая төгрөгийн дансны авлага, 28.5 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг бусад авлагаар ангилан, тайлагнасан алдаа гаргасан нь НББОУС 1(29)-д "Аж ахуйн нэгж ижил төстэй зүйлсийн материаллаг анги тус бүрийг тусад нь толилуулах ёстой...", Сангийн сайдын 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-т "Дансны авлага нь аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил,



даатгалын төлбөрт өмнөх онтой харьцуулахад тайлант жилд илүү зарцуулалт хийсэнтэй холбоотой байна.

Авлага өмнөх оноос 189.5 сая төгрөгөөр өссөн бөгөөд 8,562.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлагын үлдэгдлийн 95.6 хувь буюу 8,214.9 сая төгрөгийг ДҮТ ТӨХК-с авах цахилгаан эрчим хүчний авлага эзэлж байгаа бөгөөд тус авлагаас 30.2 хувь буюу 2,485.0 сая төгрөг нь 2 жилээс дээш насжилттай агаарын бохирдлыг бууруулах сангийн төсөл хөтөлбөрөөр шөнийн тариф тэглэсэнтэй холбоотой авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15.7 хувиар буюу 1,608.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд нийт 64,285.7 сая төгрөгийн материал орлогод авч, 62,677.1 сая төгрөгийн материалыг үйлдвэрлэлд зарцуулан 11,872.2 сая төгрөгийн материалын үлдэгдэл байгаагаас шалтгаалжээ. Бараа материалын үлдэгдлийн 51 хувийг агуулахын болон зуухны сэлбэг материал, 28 хувийг нүүрс, 15 хувийг мазут, үлдсэн 6 хувийг бусад материал эзэлж байна.

Урьдчилж төлсөн дансны үлдэгдэл 4,552.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө оруулалттай холбоотойгоор Комфорт импекс ХХК-д 4,000.0 сая төгрөг, нүүрсний тээврийн хөлсөнд УБТЗ ТӨХК-д 839.5 сая төгрөгийн урьдчилгаа төлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2.8 хувиар буюу 6,577.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна. Тайлант жилд 13,262.3 сая төгрөгийн их засвар, 1,135.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө нэмэгдэж, 4,317.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасан, 20,974.9 сая төгрөгийн элэгдэл тооцон хөрөнгийг бууруулсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 48.3 хувиар буюу 3,974.5 сая төгрөгөөр өссөн нь мөнгөн хөрөнгийн эргэлтээс хамааран төлбөр тооцоо хойшлогдсоноос шалтгаалжээ. Нийт богино хугацаат өглөгийн 41.4 хувь буюу 5,054.7 сая төгрөг нь Багануур ХК-с авсан нүүрсний худалдан авалтаас, 32.8 хувь буюу 4,006.5 сая төгрөг нь бараа материал, сэлбэг хэрэгсэл худалдан авалтаас үүссэн, 15.8 хувь буюу 1,934.9 сая төгрөг нь 2020 онд төлөх урт хугацаат зээл, хүүгийн төлбөр, үлдсэн 10.0 хувь буюу 1,213.3 сая төгрөг нь татвар, нийгмийн даатгал, гэрээт ажлын барьцааны төлбөр, бусад өглөгийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн 78.0 хувь буюу 17,045.3 сая төгрөг нь урт хугацаат зээл, 9.6 хувь буюу 2,091.1 сая төгрөг нь БНЧУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн төслийн хөрөнгөтэй холбоотой үүссэн хойшлогдсон орлого, 7.7 хувь буюу 1,687.7 сая төгрөг нь хойшлогдсон татварын өглөг, үлдсэн 4.7 хувь буюу 1,026.9 сая төгрөг нь хойшлогдсон хүүгийн өр төлбөр тус тус эзэлж байна. Урт хугацаат зээл, хүүгийн өр төлбөрийн хувьд компани 1998-2017 оны хооронд эрчим хүчийг сэргээн засварлах, дулааны үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр 6 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байгаатай холбоотой хүлээн авсан зээл, зээлийн хүү байна.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь нийт эргэлтэд байгаа 993,627,829 ширхэг буюу 99,362.8 сая төгрөгийн энгийн хувьцаатай байна. Мөн Эрчим хүчний яамны шалгалтаар 38,694.6 сая төгрөгийн газар эзэмших эрхийг эздийн өмчийн бусад хэсэгт тайлагнах зөвлөмж өгсний дагуу ангилал шилжүүлэн тайлагнасан.

2.9. Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга

Төрийн албаны тухай хуулийн 53 дүгээр зүйлийн 53.1-д заасны дагуу стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулахад эрх бүхий байгууллага, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн нь энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан төрийн албаны зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК тайлант онд 116,239.3 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөн Эрчим хүчний сайдын тушаалаар батлуулснаас гүйцэтгэлээр

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 116,881.9 сая төгрөгөөс тооцон 1,168.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 881.5 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөр, өмчийн данс материаллаг өөрчлөлттэй гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	20,851.7	26,493.1	5,641.4
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,861.5	1,152.6	(708.9)
Авлага	8,373.1	8,562.5	189.5
Бараа материал	10,263.5	11,872.2	1,608.7
Урьдчилж төлсөн зардал	353.6	4,905.7	4,552.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	235,720.6	229,197.7	(6,522.9)
Үндсэн хөрөнгө	196,317.7	189,783.7	(6,534.1)
Биет бус хөрөнгө	39,119.3	39,076.1	(43.3)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	204.8	204.8	0.0
Дуусаагүй барилга	78.8	133.3	54.4
Нийт хөрөнгийн дүн	256,572.4	255,690.8	(881.5)
Богино хугацаат өр төлбөр	8,234.9	12,209.4	3,974.5
Урт хугацаат өр төлбөр	23,934.0	21,850.9	(2,083.1)
Өмчийн дүн	224,403.5	221,630.5	(2,773.0)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	256,572.4	255,690.8	(881.5)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тайлант хугацаанд нийт 115,708.3 сая төгрөгийн орлого төвлөрч, нийт 116,417.2 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Нийт мөнгөн орлогын 73.5 хувь буюу 84,993.3 сая төгрөг нь ДҮТ ТӨХК-с, 20.1 хувь буюу 23,262.4 сая төгрөг нь УБДС ТӨХК-с төвлөрсөн бөгөөд жилийн туршид хийсэн нийт зарцуулалтын 36.7 хувь буюу 42,724.0 сая төгрөгийг Багануурын уурхайд, 19.9 хувь буюу 23,171.6 сая төгрөгийг цалинд, 14.2 хувь буюу 16,536.3 сая төгрөгийг татвар, нийгмийн даатгалд, 13.7 хувь буюу 15,941.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, сэлбэг, материалын үнэнд, 7.1 хувь буюу 8,269.9 сая төгрөгийг их засварын ажилд, үлдсэн 3.3 хувь буюу 3,840.0 сая төгрөгийг төмөр замын зардалд тус тус төлсөн байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 38.1 хувь буюу 708.9 сая төгрөгөөр буурсан нь сэлбэг материал, цалин, татвар, нийгмийн



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эх орноо хөгжилд хөтлөх эрчим хүчийг бүтээнэ” уриаг эрхэм болгож цахилгаан ба дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах, дулааны зохицуулалттай хангаж ажиллахад оршино.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх
- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Цахилгаанаар зохицуулалттай хангах
- Дулааны зохицуулалттай хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын багц хуулиуд
- Эрчим хүчний яам, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо болон Монголын эрчим хүчний ассоциацийн Эрчим хүчний салбарын 2019-2020 оны хамт/тариф/-ын хэлэлцээр
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21, 22, 24, 28, 29 33 дүгээр зүйл дэх заалтуудад 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцсэн байна.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Юникус” програм хангамж ашигладаг байна.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

2. Аудитын тайлан

2.1. Оршил

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, торуулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Чинбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн бараа материалын үлдэгдэлд үнэ цэний бууралтыг тооцох, бүртгэлийн програмд хөгжүүлэлт, сайжруулалт хийх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС, тэдгээрт нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС, тэдгээрт нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Хүлэгтхүннү аудит ХХК-ийн ахлах аудитор И.Гүррагчаа, аудитын ахлах менежер Ч.Ичинхорол, аудитын менежер Ц.Дуламсүрэн, Э.Энхзаяа, аудиторын туслах Г.Мишээлт, Э.Цолмон, Б.Мөнхчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 1/636 дугаар албан бичгээр, Хүлэгтхүннү Аудит ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/376 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Үүрэг хариуцлага

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага гоёруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

"ДУЛААНЫ ГУРАВДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЧИНБАТ
ТАНАА

2020.03.13 № 06/882
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	11
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн зорилтот түвшний тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2020/65/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Ц.Хосжаргал

Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Аудитор Д.Болор-Эрдэнэ

Утас: 261740 Цахим хаяг: bolorerdened@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Хүлэгтхүннү аудит" ХХК

Утас: 99100065 Цахим хаяг: gurragchaa@hulegthunnu.mn

Улаанбаатар хот
2020 он